



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ нь олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлсэн, нийтийн ашиг сонирхлын төлөө үйл ажиллагаа явуулдаг компаниудын засаглалыг сайжруулах замаар хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, үүний үр дүнд санхүүгийн зах зээлийн тогтвортой хөгжлийг бий болгон эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулах зорилготой, гишүүнчлэлтэй, нийгэмд үйлчилдэг мэргэжлийн институт юм.



ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 3-р сарын 9-ний өдрийн 69 тоот тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангуулах бүрэн эрхийн дагуу Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 187 дугаар тогтоолоор Компанийн засаглалын үндэсний зөвлөлийг байгуулж үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.

Хөтөлбөрийг хэрэгжүүлж дууссантай холбогдуулан Санхүүгийн Зохицуулах Хорооны 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 444 дүгээр тогтоол, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 24 дүгээр тэмдэглэлээр хөтөлбөрийг үргэлжлүүлэн бүрэн хангуулах төр, хувийн хэвшлийн хамтарсан түншлэлд тулгуурлан мэргэжлийн институтын түвшинд өөрсдийн үйл ажиллагаагаар санхүүжүүлж ажиллахаар шийдвэрлэсэн.

Олон улсын туршлагаас харахад компанийн засаглалыг зөвхөн төрийн байгууллага хууль, захиргааны хэм хэмжээ тогтоосон журмаар шаардлага тавьж албадлагын механизмаар хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдаг байна. Иймд төр-хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан хараат бус, бие даасан зохион байгуулалттай мэргэжлийн институт нь компаниудад засаглалаа сайжруулахыг зөв ойлгуулж сайн дураар даган мөрдөх тогтолцоог бэхжүүлж байгууллагын соёл болгон хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Бизнес ёс зүйтэй байж ашиг орлого нэмэгдэн улмаар улс орны эдийн засагт үнэтэй хувь нэмэр оруулдаг байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн сайн засаглалын зарчмуудыг монгол улсын компаниудын үйл ажиллагаанд хэвшүүлэх замаар компанийн засаглалыг сайжруулж улмаар эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах

ЗОРИЛТУУД

- 1 Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах ажлын хүрээнд компаниудын мэдээллийн ил тод байдлыг хангуулах
- 2 Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн зорилтод заасны дагуу компанийн засаглалын түвшний үнэлгээ хийх, олон нийтэд мэдээлэх асуудлыг тогтмолжуулан хэвшүүлэх
- 3 Компанийн тухай хуулийн 75.8-д заасны дагуу компанийн засаглалын чиглэлээр зохион байгуулах сургалтын чанарыг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- 4 Компанийн тухай хуулийн 79.2-т заасны дагуу компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг сонгох шалгуур үзүүлэлтийг сайжруулах
- 5 Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн хооронд үүссэн маргааныг зохицуулах, эвлэрүүлэн зуучлах оновчтой арга механизмыг бүрдүүлэх

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

1. Д.Ганбаяр – Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн Дарга
2. Б.Лхагважав – Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимийн Ерөнхийлөгч
3. Б.Аюуш - Жаргалтхаан хайрхан консалтинг компанийн Захирал
4. М.Болор – Санхүүгийн үйлчилгээний Элүдэй ХХК-ийн Захирал /МХБ-ийн Гүйцэтгэх захирал асан/
5. Б.Гантулга – Монголын ачаа тээврийн биржийн Гүйцэтгэх захирал
6. О.Батбилэг – Санхүүгийн зохицуулах хорооны гишүүн, Дэд дарга
7. Ц.Баяр-Эрдэнэ – Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Бодлого төлөвлөлт, удирдлагын Хэлтсийн Дарга
8. Н.Мандуул – Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын Хэлтсийн дарга
9. Э.Тамир – Эрдэнэс Монгол ТӨХК, ТУЗ-ийн нарийн бичгийн Дарга
10. Д.Баттулга – Монголын хөрөнгийн биржийн Хяналт, шалгалтын Албаны захирал
11. Ц.Оюундарь – Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Ерөнхий захирал
12. Ч.Чимэдсүрэн – Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын Гүйцэтгэх захирал
13. Ц.Хуяг – Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга
14. Ойбек Халилов – Монголын даатгагчдын холбооны Ерөнхийлөгч
15. Д.Сүндий – Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны Удирдах зөвлөлийн гишүүн



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 3 дугаар
сарын 9-ний өдөр

Дугаар 69

Улаанбаатар
хот

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. "Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр" батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд С.Баярцогт даалгаж, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайханд зөвлөсүгэй.

а/ "Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн эхний үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах;

б/ хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг Монгол Улсын 2011 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгах;

в/ хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг жил бүрийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх Үндсэн чиглэлд, шаардагдах хөрөнгийг Санхүүгийн зохицуулах хорооны төсөвт жил бүр тусган санхүүжүүлэх;

г/ хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээг хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламж, гадаад оронтой тогтоосон хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрт хамруулах ажлыг зохион байгуулах.

3. "Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөл байгуулан ажиллуулахыг Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайханд зөвлөсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАТБОЛД

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Ч.ХҮРЭЛБААТАР

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ПОРТАЛ

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

Гараад худалдааны эргэлт жилийн дүнгээр 8.4% буурсаа
2016-11-16 15:37:34

Нефтийн үнэ таван хувиар нэмэгдээ
2016-11-16 12:18:11

Хөрөнгө оруулагчдын эрх шийгш хамгаалаа
2016-11-15 15:24:00

тулд хууль төсвийн
ийн төлөв байдал

Датгалын засаглал
Батгалын байгууллага ба төр зүйнх компанийн засаглал

Бүтэц

ХЭРЭГЖҮҮЛЭХ

ХЭД ХҮРЭГ МЭДЭЭЛЭЛ

ХӨНДӨЛӨЙН ҮНЭЛТ ЭЗ ХИЙГЭХ

Сайн засаглал #1 Хаа...

МОНГОЛ УЛСЫН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТАЙЛАН 2015

МОНГОЛ УЛСЫН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТАЙЛАН 2013

КОМПАНИЙН ЗАСАГЛ

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ



МОНГОЛ УЛС САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2015 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 444

Улаанбаатар хот

"Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний
хөтөлбөр"-ийн зорилтыг үргэлжлүүлэн хангуулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Улсын их хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан "Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм"-ийн 4.2, Засгийн газрын 2011 оны 69 дүгээр тогтоолын 3 дахь заалт, Хорооны 2012 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн ажиллах дүрмийн 1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 4.6 дахь хэсгийн дагуу хөтөлбөрийн хэрэгжилтийн эцсийн тайланг хэлэлцэж дэмжсэн тул Засгийн газарт танилцуулж, нийтэд мэдээлэхийг Компанийн засаглалын үндэсний зөвлөл /Д.Ганбаяр/-д зөвшөөрсүгэй.

2. "Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хугацаа дуусч байгаа хэдий ч олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлсэн, нийтийн ашиг сонирхолын төлөө ажилладаг компаниудын засаглалыг илүү сайжруулах шаардлага байгааг харгалзан хөтөлбөрийн зорилтыг үргэлжлүүлэн хангаж ажиллахыг Компанийн засаглалын үндэсний зөвлөл /Д.Ганбаяр/-д даалгасугай.

3. Санхүү, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, компанийн засаглалын үнэлгээ хийж олон нийтэд мэдээлэх, компанийн ил тод байдлыг хангуулах тэрэг бусад ажлыг Компанийн засаглалын үндэсний зөвлөл нь төр, хувийн хэвнэлийн хамтарсан хэлбэрээр мэргэжлийн институтын түвшинд үйл ажиллагаа явуулах нь зүйтэй гэж үзсүгэй.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдааны 24 дүгээр тэмдэглэлд:

"ХҮ.3. Засгийн газрын 2011 оны 69 дүгээр тогтоолоор баталсан Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд Б.Болорт даалгаж, Санхүүгийн зохицуулах хороо (З.Батболд)-нд зөвлөв:

1. Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг үргэлжлүүлж, цаашид Засгийн газрын тухай хуулийн 19 зүгээр зүйлд заасны дагуу төрийн зарим чиг үүргийг тус зөвлөлд хариуцуулан гүйцэтгүүлэх талаар санал боловсруулж Засгийн газарт танилцуулах;

2. Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг дараах асуудлын хүрээнд чиглүүлж ажиллах:

2.1. хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах ажлын хүрээнд хувьцаат компаниудын мэдээллийн ил тод байдлыг хангуулах;

2.2. Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн зорилтод заасны дагуу компанийн засаглалын түвшний үнэлгээ хийх, олон нийтэд мэдээлэх асуудлыг тогтмолжуулан хэвшүүлэх;

2.3. Компанийн тухай хуулийн 75.8-д заасны дагуу компанийн засаглалын чиглэлээр зохион байгуулах сургалтын чанарыг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

2.4. Компанийн тухай хуулийн 79.2-т заасны дагуу компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг сонгох шалгуур үзүүлэлтийг сайжруулах;

2.5. хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн хооронд үүссэн маргааныг зохицуулах, эвлэрүүлэн зуучлах оновчтой арга механизмыг бүрдүүлэх." гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

ГОЛ ХИЙСЭН АЖЛУУД

- ✓ Засаглал болон түүний хууль эрх зүйн орчинг сайжруулахаар Компанийн тухай хууль, Үнэт цаасны тухай хууль, Компанийн засаглалын кодексийг шинэчлэн батлуулж хэрэгжилтийг хангуулахаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж ирсэн.
- ✓ Компанийн засаглалыг хөгжүүлэх бодлогын түвшинд заавар, зөвлөмж боловсруулан хэд хэдэн жишиг журам гаргасан.
- ✓ Компаниудын нээлттэй мэдээллийг ил тод болгох зорилгоор засаглалын үндэсний портал сайт “www.governance.mn”-г тогтмол хөгжүүлж байна.
- ✓ “Монголын хөрөнгийн бирж”, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар”, “Санхүүгийн зохицуулах хороо” болон мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах санамж бичиг байгуулан холбогдох салбарын компанийн засаглалыг сайжруулахаар хамтран ажиллаж байна.
- ✓ Компанийн тухай хуулийн 75.8-д заасны дагуу компанийн засаглалын гэрчилгээ олгох сургалтын хөтөлбөр боловсруулж 80 гаруй сургагч багшийг бэлтгэн 12 сургалтын байгууллагатай гэрээ байгуулж нийт 4000 гаруй ТУЗ-ын дарга, гишүүдийг сургалтанд хамруулж гэрчилгээ олгосон.

ҮЙЛ АЖИЛЛАГАА

- **Монгол Улсын компанийн засаглалын судалгаа, үндэсний тайлан**
 - Салбарын түвшинд компанийн засаглалын судалгааг хоёр жил тутам хийж олон нийтэд хүргэх
 - Засаглалын түвшинг тогтоож зөвлөмж гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэх
- **Компанийн ил тод нээлттэй байдлыг хангуулах**
 - Бизнес, компанийн үйл ажиллагааг нийтэд зөвөөр таниулахад чиглэсэн нэвтрүүлэг, мэдээ бэлтгэх
 - Компанийн засаглалын портал сайтаар, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр нийтэд ил тод мэдээлэх
 - Компанийн үйл ажиллагааны тайлан, нээлттэй байдлыг хангахад арга зүйгээр дэмжлэг үзүүлэх
- **Компанийн засаглалыг кодексын хэрэгжилтийг хангуулах**
 - Компанийн засаглалын сургалтанд хамрагдсaдын нэгдсэн мэдээллийн бааз бүрдүүлэх
 - Компанийн засаглалын сайжруулах чиглэлээр байгууллагуудад судалгаа хийх
 - Засаглалыг сайжруулах чиглэсэн зөвлөгөө өгч хэрэгжилтийг хангуулах
- **Компанийн засаглалын үнэлгээ хийж зөвлөмж боловсруулах**
 - Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үнэлгээ хийж, зөвлөмж өгөх
 - Компанийн засаглалын үнэлгээ хийж түвшинг тогтоох, батламж гардуулах
- **Эрх зүйн баримт бичиг боловсруулахад мэргэжлийн арга зүйгээр хангах**
 - Засаглалтай холбоотой дүрэм, журам, гарын авлага боловсруулах, сайжруулахад арга зүйгээр хангах
- **Салбарын түвшинд засаглалтай холбоотой асуудлаар авах арга хэмжээ**
 - Компанийн засаглалын нарийвчилсан, ахисан түвшний сургалт зохион байгуулах
 - Компанийн засаглалын тулгамдсан асуудлуудаар хэлэлцүүлэг өрнүүлэх
 - Дотоодын болон олон улсын сургалт, семинарт хамрагдуулах
- **Хувьцаа эзэмшигчдийн маргааныг шийдвэрлэх үйл ажиллагаа явуулах**
 - Хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх холбоотой маргаан, асуудлыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх
 - Оролцогч талуудын хүсэлтээр хууль зүйн дүгнэлт гаргах эвлэрүүлэх үйл ажиллагаа явуулах
- **Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгоход мэргэжлийн туслалцаа үзүүлэх**
 - ТУЗ-д ажиллах хараат бус гишүүдийн зарыг олон нийтэд оновчтой хэлбэрээр хүргэх
 - Хараат бус гишүүнд нэр дэвшигчдийг шаардлагын дагуу судалж санал болгох
- **Гишүүн байгууллага, хувь хүмүүст зориулсан тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх**
 - Гишүүн байгууллагад дээрхи үйлчилгээг хөнгөлттэй нөхцөлөөр гэрээний үндсэн дээр гүйцэтгэх
 - Хувь гишүүдийг чадавхижуулах, арга хэмжээнд үнэ төлбөргүй хамрагдуулах, дэмжлэг үзүүлэх

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Монгол улс, Улаанбаатар-15160
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо
Бага тойруу - 3
Жи-Мобайл байр, 301тоот

Утас: +976-90097272
Э-шуудан: contact@governance.mn
Вэб хуудас: www.governance.mn